



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/540

Эрдэнэт

Өмчлөх эрх олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2.1.2 “г”, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан дуудлагын худалдаагаар худалдагдсан аймгийн Цагдаагийн газарт ашиглаж байсан Хьюндэй Элентра маркийн 29-87 ОРХ улсын дугаартай суудлын авто машиныг, Тоёота чейзер маркийн суудлын авто машиныг, Хьюндэй Соната-4 маркийн 71-41 ОРХ улсын дугаартай суудлын авто машиныг, Верна аксент маркийн 26-55 ОРО улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Н.Ганцоож, Тоёота марк-2 маркийн 94-92 ОРО улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Э.Цэнд-Аюуш, “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-д ашиглаж байсан Донг Пэнг маркийн 30-23 ОРХ улсын дугаартай авто машиныг иргэн А.Амарбаяр, Донг Пэнг маркийн 30-22 ОРХ улсын дугаартай авто машиныг, Исузу маркийн 10-31 ОРХ улсын дугаартай авто машиныг иргэн Г.Хаян, Хьюндэй Соната-2 маркийн 86-41 ОРО улсын дугаартай суудлын авто машиныг, “Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-т ашиглаж байсан Хьюндэй старекс маркийн 63-35 ОРХ улсын дугаартай авто машиныг иргэн Н.Ганцоож нар тус тус худалдан авсан тул өмчлөх эрх олгосугай.

2.Дээрх авто машинуудыг Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлээс хасч, шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөхийг Орон нутгийн өмчийн газарт, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл, балансаас хасахыг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



А.ТҮВШИНЖАРГАЛ